

БАЙГАЛЬ ШИНЖЛЭЛ

Адьясүрэн Ц. **Байгаль орчин, тогтвортой хөгжил, хүний хөгжил**: Судалгааны өгүүллийн эмхэтгэл. –УБ.: Тоонотпринтг, 2010. -524х.

Монгол улсын байгаль орчин, менежментийн салбарын нэртэй эрдэмтэн, судлаач, төр нийгмийн зүтгэлтэн Ц.Адьясүрэн байгаль орчны салбарт 30 гаруй жил ажиллахдаа байгаль орчин, ган, цөлжилтийн талаар 30-д судалгаа эрдэм шинжилгээний өгүүлэл бичжээ. Тэдгээр өгүүлүүдээ байгаль орчны бодлого, стратеги., газрын бодлого, менежмент., ган цөлжилт, гамшигтай тэмцэх тухайд., Монгол улсын тогтвортой хөгжлийн үнэлгээ, үр дүнгээс., хүрээлэх орчныг хамгаалах нь., экологи, тогтвортой хөгжлийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх тухай гэсэн 6 бүлэгт хуваан энэ номондоо оруулжээ.

20.18

А-29

/БШУН унш-7ш/

Б-20358-20364

Лхамсүрэн Ц., Батболд Ц. **Сонгодог математикийн сувд эрдэнэс**. –УБ.: 2001. -227х.

Сонгодог математикийн сувд эрдэнэс мэт үнэлэмжтэй “Алгебрийн үндсэн теором”, “Валлис, Стирлингийн томъёо”, “Пифагорын теорем” гэдэг нэрээр алдаршсан математикийн аугаа их нээлтүүдийн олон тооны шилмэл баталгааг онолын зохих түвшинд, математик сонирхогч өргөн олон нийтэд хүртээмжтэй байхаар энэ номонд багтаан математик сонирхогч нийт уншигчдад зориулж байна.

22.12


Л-87

/БШУН унш-3ш/

Т-14861-14862



Баасан Тү. **Монголын говь**. –УБ.: Адмон, 2010. -288х.



“Монголын говь” хэмээх энэхүү номноос уншигч та монголын нутаг дэвсгэрт байгаа 33 биш 377 говийн ерөнхий төрх, хэмжээ, хэв шинж, мөн тэнд ургадаг ургамал, амьдардаг амьтадын тухай мөн цөлжилт, түүнийг үнэлэх, гандуу нутгийн экосистемийг хамгаалах асуудлуудын талаар мэдэж авах болно.

26.82

Б-10

/БШУН унш-7ш/

Б-20344-20350

Жаргалсайхан С. **Бүгд Найрамдах Хятад Ард Улс** /Хян. Орч. Л. Бэгзжав. – УБ.: Оргилпресс, 2011. – 201 х.


Хятад судлалч С. Жаргалсайханы энэ номд Хятадын олон муж, ӨЗО, хотууд, ЭЗТБ-үүдийн онцлог, нутаг нутгийн ялгаа, ёс заншил, хоол ундны талаар хятад эх сурвалжид тулгуурлан сонирхолтой, баримттай өгүүлснээрээ шинэлэг бөгөөд хятад орныг, хятад хүмүүсийг танин мэдэхэд нэн тустай олон зүйлийг өгүүлэх аж. БНХАУ-ын тухай товчхон болоод мэдээлэл сайтай, лавлагааны шинжтэй, хятад хэл сурч буй оюутан сурагч төдийгүй хятадыг сонирхогч, харилцагч, хэн бүхний анхаарлыг татаж чадах номыг туурвижээ.

26.89/Хят/

Ж-31

/НХШУН унш-2ш/

Б-21054-21055



Санжмятав З. **Ландшафт судлал** /Ред. С Хадбаатар. – УБ: 2011. – 89 х.

Физик газарзүйн салбар ухаанууд дотроос эрчимтэй хөгжиж үр дүнд хүрч буй нь ландшафт судлал юм. Иймд энэхүү бүтээлийн 1-р бүлэгт ландшафт түүний хөгжлийн үе шат, 2-р бүлэгт ландшафт судлалын зарим асуудал, 3-р бүлэгт ландшафтыг бүрдүүлэгч

хүчин зүйлс, 4-р бүлэгт ландшафтын морфологийн төрлүүд, хэв шинжийн ландшафтууд, нэр томъёоны тайлбар зэргийг тус бүр авч үзжээ.

26.82

C-31

/БШУН унш-7ш/

Б-21056-21058

Санжмятав С. **Монгол орны байгалийн газарзүй**: 2-р хэвлэл /Ред. Д. Даш. – УБ.: 2011. – 176 х.



Энэ хоёр дахь бүтээлд газарзүйн байрлал, онцлог, байгалийн газарзүйн судалгааны тойм, хотгор-гүдгэрийн ерөнхий газрын доорх ус, нуур, хөрс, хөрсөн бүрхэвчийн онцлог, ургамлын, амьтны аймгийн тойм, ландшафт-байгалийн мужууд гэсэн бүтэц бүхий зүйлүүдэд ялган бичжээ.

26.81/1/

C-31

/БШУН унш-2ш/

T-14891-14893



Жанчив Ц. **Популяцын генетик**. –УБ.: 2008. -104х.

Энэхүү бяцхан номонд популяцын генетикийн асуудлуудыг популяцын генетик тогтоц, эволюцын эгэл процессууд, байгалийн шалгарал, инбридинг, генетик коадаптаци, газарзүйн төрөлжилт, макроэволюци, монгол улс дахь популяцын генетикийн судалгаа гэсэн 7 бүлэгт хуваан авч үзжээ.

28.04

Ж-28

Б-21050

**Хэрлэний хөдөө аралд тарьсан нэн ховор, ховор, ашигт ургамал** /Жамьяндорж Х., Лигаа У., Отгонбилэг Х., Саарал Н. –УБ.: Улаанбаатар принт, 2011. -623х.

Энэхүү номонд ургамал тарималшуулах, нутагшуулах, шинжлэх ухааны үндэслэл, нутагшсан сорт, хэлбэрийн морфологи, биологийн онцлог, анхдагч үрийн аж ахуйн судалгаа, нэн ховор, ховор, ашигт ургамал, таних онцлог, тэдгээрийн Монгол дахь тархац, ургахуйн орчин, тарих арга, усалгаа, хэрэглээ, ач холбогдлын талаар товч өгүүлжээ. Зүйл тус бүрийн монгол, латин, орос, англи нэрс хамаарах овгийг дурджээ. ХААИС болон МУИС-ийн ургамал судлаач эрдэм шинжилгээний ажилтан, багш, магистрант оюутан болон ургамал судлаач нийт уншигчдад зориулагджээ.

28.58

X-91

/БШУН унш-7ш/

T-14855-14857



## ЦАХИЛГААН ТЕХНИК, КОМПЬЮТЕР



Баярсайхан Ц. **Цахилгаан техникийн үндэс**: Сурах бичиг /Ред. З. Цэрэндорж, Шангар. – УБ.: Мөнхийн үсэг, 2011. – 392 х.

Энэхүү сурах бичиг нь 21 бүлэг, 129 дэд бүлэг бүхий онолын үндэс ба нийт 500 гаруй тайлбар зураг, схем, график, 300 гаруй жишээ бодлого, 500-н бие даалтын бодлогоос бүрджээ. Мөн үүнд цахилгаан хэлхээний онолыг практикт хэрэглэх тооцооны аргачлалуудыг түлхүү оруулж өгчээ. Энэ ном нь цахилгаан, электроникийн инженер ба бусад инженерийн салбар, техник мэргэжлийн сургуульд цахилгаан хэлхээний онол, цахилгаан техникийн үндэс хичээлийг судлаж буй багш, оюутан, сурагчдад зориулагдсан болно.

31.21

Б-38

T-14882-14883

Эрдэнэчимэг Ж. **PHP хэлний хэрэглээ**: Объект хандалтат: Өгөгдлийн сантай ажиллах PDO: Зураг боловсруулах GD сан /Ред. Б. Энхтуул. – УБ.: МУИС, ХҮС-ийн хэвлэх, 2011. – 321 х.



Тус ном нь PHP програмчлал сонирхогч, эхлэн суралцагч болон энэ хэлний тодорхой мэдлэгтэй хүмүүст зориулагдажээ. Гол зорилго нь PHP хэлний практик хэрэглээнд нь голлон анхаарч блог програмыг хэрхэн байгуулахыг нэг бүрчлэн бичжээ. Номын эхний хэсэгт PHP хэл дээр програм бичиж эхлэх бэлтгэл, дунд хэсэгт хэлний практик хэрэглээг сургах зорилгоор блог сайтыг байгуулах болон сүүлийн хэсэгт блог сайтаа улам боловсронгуй болгох гэсэн үндсэн 3 хэсэг 12 бүлгүүдтэй. Энэ номыг их, дээд сургуулийн “Вэб програмчлал”, Вэб технологи” зэрэг хичээлүүдэд ашиглах болно.

32.973-018.1

Э-73

/БШУН унш-7ш/

Б-21051-21053

### МАЛЫН ТҮҮХИЙ ЭД СУДЛАЛ



Цэндсүрэн С. **Мал, амьтдын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах технологи**: 3 дахь хэвлэл /Ред. Б. Лувсаншарав. – УБ.: Солонго, 2008. – 337 х.

Энэхүү шинэчлэн баяжуулж бичсэн 3 дахь хэвлэл нь 8 бүлгийг агуулжээ. Үүнд: сүү цагаан идээ, нядалгаанд орох малд тавих үндсэн шаардлага, мах, махны тухай ойлголт, махан бүтээгдэхүүн боловсруулах арга, малын гаралтай дайвар бүтээгдэхүүн, арьс ширэн түүхий эдийн бүтэц, анхан шатны боловсруулалт, арьс ширэн түүхий эдийг эдэлж боловсруулах, туслах аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах гэсэн бүлгүүдтэй энэ сурах бичгийг хүнс, хөдөө аж ахуй, биотехнологи, мал аж ахуйн мэргэжилтнүүд, их, дээд сургуулийн оюутан, магистрант, докторантууд, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллагсад болон мал, амьтдын ашиг шимийг хүртдэг хүн бүхэнд хандуулж байна.


36

Ц-95

/БШУН унш-2ш/

T-14849-14850

Халиун М. **Монголын ноос ноолууран бүтээгдэхүүн, тэдгээрийн брэнд-Олон улсын зах зээлд** /Ред. Б. Мягмаржав. – УБ.: Артсофт, 2011. – 136 х.



Монгол орны ноос, ноолууран бүтээгдэхүүн нь олон улсын болон дэлхийн зах зээлд монголын ноос, ноолуур гэсэн брэнд нэрийг бий болгон үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болж байгаа. Зохиогч маань энэхүү сэдвээр бакалавраа хамгаалжээ. Энэхүү бүтээл нь 3 бүлэгтэй. Үүнд: 1. монголын ноос, ноолууран бүтээгдэхүүнд нөлөөлөх хүчин зүйл, 2. монголын ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүний брэндийн өнөөгийн байдлын үнэлгээ, чиг хандлага, 3. монголын ноос, ноолууран бүтээгдэхүүн, тэдгээрийн брэнд олон улс болон дэлхийн зах зээлд гэсэн бүлгээс гадна 25 хүснэгт, 25 зураг, 20 диаграм зэрэг хавсран оржээ.

37.233.1

X-19

/БШУН унш-3ш/

Б-21059-21060

### ОЙ СУДЛАЛ



Базарсад Ч., Батэрдэнэ Ж., Цэнгэл Б. **Ойн аж ахуйн үндсэн ажлууд**: Үрийн аж ахуй, мод үржүүлэг, ойжуулалт, тусгай зориулалтын ой, хамгаалалтын ой. –УБ.: Мөнхийн үсэг, 2011. –417х.

Энэхүү сурах бичиг нь үрийн аж ахуй, мод үржүүлэг, ойжуулалт, тусгай зориулалтын ой, хамгаалалтын ой үржүүлэг гэсэн үндсэн бүлгүүдийг багтаасан бөгөөд манай орны нөхцөлд энэ талаар судалгаа явуулсан эрдэмтдийн бүтээлүүдээс иш татаж оруулжээ. Энэ сурах бичгийг ойн аж ахуйн инженер, ой, ургамал, хөрс судлаач, экологийн чиглэлээр сурч буй бакалавр, магистрантур, ажилтан нарт зориулжээ.

43.4

Б-34

/БШУН унш-7ш/

Б-20371-20377

### МАЛ АЖ АХУЙ

Мягмаржав Б. “Умард Африкийн нүүдлийн мал аж ахуй-Дэлхийн зах зээлд” ҮН боть. – УБ.: Ном хур, 2011. – 162 х.

Дэлхийн нүүдлийн мал аж ахуй, түүний дотроос Африкийн нүүдлийн мал аж ахуйн бүрэлдхүүн хэсэг нь Умард Африкийн орнууд юм. Эдгээр оронд Алжир, Ливи, Марокко, Тунис, Египет, Судан орнууд багтана. Энэхүү бүтээл нь үндсэн 3 хэсэгтэй. 1-рт: Африкийн мал аж ахуй ба Умард Африкийн нүүдлийн мал аж ахуй, 2-рт: нүүдлийн мал аж ахуйн харьцуулсан судалгаа, 3-рт, нүүдлийн мал аж ахуй ба нийгэм эдийн засгийн цогц гэж судлан хуваажээ. Үүнээс гадна Судан орны нүүдлийн мал аж ахуйг хэд хэдэн бүлэгтэйгээр тусгай бие даан оруулжээ.



45/61/

М-98

/БШУН унш-3ш/

Т-14889-14890

### НИЙГМИЙН АЖИЛ



**Нийгмийн ажлын онолын үндэс:** Гарын авлага /Эмх. Т. Амаржаргал, С. Туяа, Хян. Т. Амаржаргал, Т. Оюунбилэг. – УБ.: 2008. – 199 х.

Тус гарын авлагад нийгмийн ажлын хөгжлийн түүхэн тойм, онол, загвар, зарчим, нийгмийн ажил нийгмийн бусад шинжлэх ухаантай холбогдох нь, хүн амын янз бүрийн бүлгүүдэд үзүүлэх нийгмийн ажлын онцлог, нийгмийн хамгааллын хууль эрх зүй, нийгмийн ажлын мэргэжилтний шалгуур, ёс зүй, ажлын үр ашиг зэрэг асуудлыг цогц байдлаар нь авч үзжээ. Гарын авлагыг нийгмийн салбарт ажиллаж буй ажилтнууд, мэргэжлийн ангийн оюутан залуус, энэ чиглэлийг сонирхон судалдаг хүмүүст зориулагдана.

60

Н-58

Б-21007-21008

### ТҮҮХ СУДЛАЛ

Баасанжав З. **Эх түүх:** Сургалтын гарын авлага /Хян. П. Дэлгэржаргал. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 178 х.

Энэхүү “Эх түүх” сургалтын гарын авлагадаа “Монголын түүх” хичээлийн танин мэдэхүйн зорилго, зорилтууд, хичээлийн лекц, лекцийн товч тэмдэглэл, семинарын үлгэрчилсэн сэдэв, мөн мэдлэг чадварыг шалгах зарим сорилуудыг багтаажээ.

63.3/1/я7

Б-10

/НХШУН унш-25ш/

Б-21031-21035



**Сэрсэн зууны түүх:** 1,2-р дэвтэр /Эрх.хэв. Д.Долгорсүрэн. –УБ.: Мөнхийн үсэг, 2011. МҮОНТ-ийн хэрэгжүүлж байгаа “XX зуун-100 жил” төсөл нь өдөр тутмын календарь, түүнийг нэгтгэсэн мөн “Энэ өдөр түүхийн хуудаснаа...” хэмээх телевизийн нэвтрүүлгийн

DVD-ны цогц, баримтат кино болон “Сэрсэн зууны түүх” хэмээх Монголын түүхийн эмхэтгэл ном гэсэн 4 цогц ажлаас бүрдэж байгаа ажээ. Уншигч танаа толилуулж буй “Сэрсэн зууны түүх” хэмээх энэхүү эмхэтгэлийн 1-р дэвтэрт 1900-2000 оны хоорондох XX зууны Монголын түүхийг арав, арван жилээр багцлан түүхэн гэрэл зургийн хамт харуулсан ба 2-р дэвтэрт өнгөрсөн зууны туулсан амьдралаас тунгаан шүүсэн асуудлуудыг эрдэмтэн мэргэд, гэрчүүдийн баримтанд тулгуурлан нийтэлсэн өгүүллүүд оржээ.

63.3/1/  
С-95

1-р дэвтэр. -291х.  
2-р дэвтэр. -329х.


T-14909-14911  
T-14912-14914

**Улаанбаатар:** Хотын хөгжил, бүтээн байгуулалт, түүхэн замнал /С.Мөнхжаргал, Д.Цэдэв, С.Лувсангомбо ба бус. –УБ.: Адмон, 2011. -224х.

Энэ номонд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын шаштир, үүсэл гарал, их бүтээн байгуулалтын он жилүүдийн түүхэн замнал, улс орны нийгэм эдийн засаг, соёлын амьдралд болж өнгөрсөн бодит баримтуудыг эрд, эдүгээ, ирээдүйтэйн, мөн өнгөт зургийн хамт тайлбарлажээ.

63.3/1М-2УБ/  
У-29

T-14908



**Хүннүгийн түүх, соёл** /Хян. Ж.Болдбаатар, П.Дэлгэржаргал. –УБ.: Соёмбо принтинг, 2011. -410х.



Хүннү гүрэн байгуулагдсан буюу монголын төр ёсны 2220 жилийн ойд зориулан гаргасан энэ номонд Хүннүгийн гарал үүсэл, нүүдэлчдийн анхны төр улс болох Хүннүгийн төрийн байгууллын үндсэн шинж, аж ахуй, эдийн засгийн байдал, соёл урлагийн хөгжил, Хүннүгийн антропологийн хэв шинж, Хүннү гүрний цаашдын хувь заяа, задралын шалтгаан, нүүдэлчдийн түүхэн дэх Хүннүгийн загварын тухай дэлгэрэнгүйгээр өгүүлжээ.

63.3/1/4  
Х-82

/НХШУН унш-7ш/

T-14896-

14898

## ЭДИЙН ЗАСАГ

Авирмэд Д. **Улсын секторын санхүүгийн дотоод хяналтын тогтолцоо:** Онол, арга зүй. –УБ.: 2011. -179х.


Энэхүү бүтээлд улсын секторын санхүүгийн дотоод хяналтын тогтолцооны боловсронгуй хувилбарыг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн тодорхойлж, санхүүгийн дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг манай орны практик түвшинд судалж, дүгнэлт гаргаж, нэгдмэл бүтцийн загварт тулгуурласан оновчтой хувилбарыг санал болгон, үр дүнгийн үзүүлэлтүүдийн тэнцвэрт системийн загварыг улсын секторын санхүүгийн дотоод хяналтанд нэвтрүүлэн хэрэглэх арга зүй, үр дүнгийн хяналт, үнэлгээний матрицын загварыг боловсруулан тусгажээ. Энэхүү ном нь улсын секторын санхүүгийн дотоод хяналтын чиглэлээр суралцаж буй болон судалгаа хийж буй хүмүүст гарын авлага болох ажээ.

65.053

А-17

/НХШУН унш-7ш/

Б-21061-21063



Мөнхбаатар Ё, Батсайхан Ж. **Монгол улсын 2010 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл:** Арга зүйн хялбаршуулсан гарын авлага. – УБ.: 2010. – 80 х.

Энэхүү гарын авлагад төсвийн орлого, зарлага, тэнцлийн үзүүлэлтүүд, тэдгээрийн тодорхойлолт, тооцдог аргачлал, 2010 оны гүйцэтгэлийн талаар ойлголт өгөх үүднээс тусгайлан тодруулгыг оруулж өгсөн байна. Мөн тухайн үзүүлэлтийн төлөвлөсөн хэмжээ,

түүний гүйцэтгэлийг харуулсан диаграм, схем зэргийг өргөн ашиглажээ. Үүнд тусгагдсан тоо баримт нь Монгол Улсын 2010 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай УИХ-ын тогтоол болон Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн танилцуулга, тооцоо, тоо баримтаас эх сурвалжтай болно.

65.261.3/1/

М-69

/НХШУН унш-3ш/

Б-21048-21049

Намжил Д. **Мөнгө зээлийн бодлого** /Хян. Ц. Аюурзана. – Орхон аймаг, 2010. – 89 х.

Энэ номд мөнгө зээлийн бодлогын үндэс, банкны системийн нөөц, банкны нөөцийг удирдах арга хэрэгсэл, мөнгө зээлийн бодлого гэсэн бүлгүүдийг хамарсан байна.

65.262

Н-25

/НХШУН унш-15ш/

Б-21026-21030



Цэдэндагва Г, Цолмонхүү О. **Хөгжлийн эдийн засаг**: Эдийн засгийн өсөлтийн онол, загвар, практик туршлага /Ред. Г. Цэрэндагва. – УБ.: МУИС, ХҮС-ийн хэвлэх, 2011. – 244 х.

Энэ ном нь 2 бүлгээс бүрдэнэ. Эхний хэсэгт энэ шинжлэх ухааны судлах зүйл, агуулгыг тодорхойлох, хөгжлийн онол, түүний үндсэн чиг хандлагыг дэлхийн эдийн засаг, аж ахуйн систем, хөгжингүй ба хөгжиж буй орнуудын хөгжлийн түүхэн туршлага, дараах хэсэгт нь манай орны зэргэлдээх 2 хөрш гүрэн болоод Здагч түнш гэгдэх Япон, Өмнөд Солонгос, АНУ, Герман, болон Монгол улсынхаа хөгжлийн тоймыг тус бүр тусгажээ.

65я73

Ц-94

/НХШУН унш-7ш/

Б-21011-21013

Цэрэндорж Д. **Дэлхийн менежмент, хамаарахуйн монгол ухаан**: Мэдэхүй, чадахуй, засахуй. –УБ.: Мөнхийн үсэг, 2011. -324х.

Уншигч та энэ номноос менежментийн ухааны үүсэл хөгжил, орчин үеийн хандлага, байгууллагын онол ба менежмент, менежерийн үйл ажиллагааны төрөл, ур чадвар, менежментийн үндсэн чиг үүрэг, байгууллагын соёл, бүлгийн сэтгэл зүй, менежментийн үйлдлэг дэх дэлхий дахины ололт туршлагууд, хэрэглээний хүрээ, засаглал, нийтийн захиргаа, менежментийн боловсролын тухай мэдэж авах болно.

65.290-2

Ц-95

/НХШУН унш-7ш/

Б-14901-14903



## УЛС ТӨР СУДЛАЛ



**Монгол улсын ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн намтар номзүйн тойм 1989-2009**: Тэргүүн дэвтэр /Эмх. Ш. Жижгээ, Ред. Т. Эрдэнэзул, Р. Алтангэрэл, Э. Энхзул, Ж. Оска. – УБ.: ШУТИС-ийн хэвлэх, 2010. – 318 х.

Манай улсын нэрт улс төрч, нийгмийн зүтгэлтэн нарын бүтээл, туурвил, ажил үйлсийн талаарх үнэ цэнэтэй, нарийн мэдээллийг цаг алдахгүй олж авахыг хүсэгчид өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа билээ. Иймээс тус бүтээлд Монгол Улсын Ерөнхийлөгч төр нийгмийн нэрт зүтгэлтэн Ц. Элбэгдоржийн сүүлийн 20 гаруй жилийн дотор хэвлэн нийтлүүлсэн зүйлийг нэгтгэн энэхүү намтар номзүйн бүртгэлийг уншигч олон та бүгдийн сонорт хүргэж байна.

66.3/1/8

М-69

Б-21023-21025

**Улс төр судлал:** Сурах бичиг /Б.Долгор, Я.төгөлдөр, Б.Энхамгалан ба бус. –УБ.: Адмон, 2011. -324х.



ШУТИС-ийн сургалтын онцлог, хичээлийн нэгдсэн хөтөлбөрт нийцүүлэн толилуулж буй энэхүү сурах бичиг нь улс төр ба хүн, засаглал, улс төрийн систем, улс төрийн нам, сонгууль, улс төрийн соёл, ардчилал ба хүний эрх, иргэний нийгэм, дэглэм, парламентат ёс, иргэдийн улс төрийн оролцоо, сонирхлын бүлэг, үндсэн хууль, улс төр ба мэдээлэл, жендерийн асуудал, даяаршлал ба улс төр гэсэн 24 бүлэгтэй ба сэдэв бүрийн дараа харилцан ярилцах, мэтгэлцэх асуултууд, тухайн сэдвээр өөрийн мэдлэгийг шалгах сорил, оюутны бие даалтын ажлаар бичих илтгэл, рефератын сэдвүүд болон бакалаврын түвшинд уншиж судлах ном, сурах бичиг, веб хуудасны жагсаалтуудыг тус тус хавсаргажээ.

66.01я73

У-31

/НХШУН унш-15ш/

T-14884-14888

### **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**



Баасан Л. **Монгол улсын хөдөлмөрийн эрх зүй:** 3 дахь хэвлэл. – УБ.: Артсофт, 2010. – 362 х.

МУ-ын хөдөлмөрийн эрх зүйн номондоо хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн дагуу ерөнай ба тусгай анги аль алиныг нь нэгтгэн оруулж өгсөн нь оюутнууд, практикийн ажилтнууд, иргэдэд нь эрх зүйн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэхэд зохих хувь нэмрээ оруулах байхаа.

67.405

Б-10

/НХШУН унш-7ш/

T-14905-14907

**Монгол улсын ашигт малтмалын хуулиуд: 1910-2010.** Монгол, англи хэл дээр /Эмх. Б.Өлзийбаяр, Б.Цэцэнбилэг. –УБ.: 2010. -268х.


Энэхүү хуулийн эмхэтгэлд Богд хаант улсын уурхайн дүрэм-1913, Ардын засагт монгол улсын уурхайн дүрэм-1923, газрын хэвлийн тухай Монгол улсын хууль-1988, Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль-1994, 1997, 2006 оны хуулиуд болон тухайн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд оржээ.

67.407

М-69

/БШУН унш-3ш/

T-14858-14860



### **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**



**Эрдэм шинжилгээний бичиг:** МУИС:НШУС: Боловсрол судлал 357/11/. – УБ.: МУИС, ХҮС-ийн хэвлэх, 2011. – 210 х.

Энэ удаагийн дугаартаа НШУС-ийн багш нарын болон их дээд сургуулийн багш нарын тавьсан “Их дээд сургуулийн багшийн ёс зүй” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд, Сургалт ба мэдээлэл харилцааны технологи-Монголын математикчдын нийгэмлэгийн 2011 оны хурлын илтгэлүүд болон бусад багш нарын бүтээлүүд нь хамрагдан оржээ.

72

Э-73

/НХШУН унш-2ш, Лав-1ш/

T-14878-14879

## МУЗЕЙ СУДЛАЛ


Цэндсүрэн Ц, Янжив А. **Музей судлалын үндэс** /Ред. Б. Сумъяа. – УБ.: Содпресс, 2010. – 229 х.

Тус бүтээлд дэлхийн музейн үүсэл хөгжлийн түүхийг эртний Грек, Ромын үеэс өнөө үеийг хүртэл тусгасан бөгөөд, музейн сан хөмрөг, үзүүллэг зохион байгуулалт, соёл боловсролын ажил менежмент ба маркетинг зэрэг музей судлалын шинжлэх ухааны үндсэн асуудлуудыг багтаан нийт соёлын ажилтан, соёл судлаач, музей болон аялал жуулчлал сонирхогчид, оюутан, сурагчдад зориулан бүтээжээ.


79.1

Ц-95

T-14880



## ХЭЛ ШИНЖЛЭЛ



Баасанбат Д., Эрдэнэочир Т. **Монгол яриа**. –УБ.: Удам соёл, 2011. -292х.

Монгол хэлний дунд болон гүнзгийрүүлсэн төвшний ангид сурч байгаа гадаадын оюутнуудад зориулсан энэхүү сурах бичигт мэндлэх ёс, ажил мэргэжлийн, баяр ёслолын, захидал бичгийн мэндчилгээний үг хэллэг, монгол ярианы танилцах, хандах, өршөөл уучлал гуйх, татгалзах, ерөөх, урих, утсаар ярихад идэвхтэй хэрэглэдэг үг хэллэг, орчуулгын богино өгүүллэгүүд, монгол өгүүллэгүүд тус тус оржээ.

81.2M-96

Б-10

/НХШУН унш-7ш/

T-14863-14865

Гомбо Б., Амаржаргал Б. **Испани хэлний сурах бичиг**. –УБ.: Содпресс, 2001. -482х.

Испани хэл судлаач уншигч та испани хэлний үндсэн 18 хичээлээс бүрдэх энэхүү сурах бичгийг үзэж дууссанаар испаниар зөв дуудаж, уншиж, хэлний үндсэн дүрмүүдийн тухай ойголттой болж, чамлахааргүй хэмжээний үгийн сантай болох бөгөөд хүндэвтэр сэдвүүдийг уншиж ойлгон, харилцан ярьж сурахаас гадна ойлгосноо найруулан ярих чадвартай болох ажээ.

81.2Исп.я73

Г-53

/НХШУН унш-3ш/

Б-21039-21040



Кручкин Ю. **Монгол-орос толь бичиг**: 10 дахь хэвлэл. –Москва-УБ.: Бемби сан, 2011. - 1252х.

Энэхүү толь бичиг нь 69 000 үг хэллэгийг багтаасан ба монгол хэлнээс орос хэл рүү орчуулга хийх мөн монгол, орос хэл сурч буй хүмүүст зориулагджээ.

81.2Мон-4

К-84

/НХШУН унш-3ш/

Б-21046-21047

Санжаа Ж. **Монгол хэлний их авиалбар, авиалбар, авианы тогтолцоо**: Үгүүлэл, товхимлын эмхэтгэл. –УБ.: 2011. -518х.

МУБИС-ийн МСС-ийн багш, доктор, профессор Ж.Санжаагийн энэхүү бүтээлийн эмхэтгэлд түүний 1977-2011 онуудад монгол хэлний их авиалбар, авиалбар, авианы тогтолцооны талаар бичсэн эрдэм шинжилгээний 60-д үгүүлэл, боловсрол, сурган хүмүүжүүлэх ухаан, заах арга зүйн холбогдолтой танин мэдэхүй-сурталчилгааны үгүүлэл, зарим нэг номонд бичсэн шүүмж оржээ.





**АМАН БОЛОН УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ**

**Жангар тууль судлал:** Олон улсын эрдэм шинжилгээний хурал. /Эмх. Т.Баярсайхан. – УБ.: Соёмбо принтинг, 2011. -169х. /Ойрад судлалын номын сан. XXII/ “Тод номын гэрэл төв” ТББ-с эрхлэн гаргадаг “Ойрад судлалын номын сан” цуврал номын XXII ботид Ээлэйн Овлайн арван бүлэг “Жангар”-ыг хэвлэсний 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг, мөн “Жангар” тууль судлалаар 1990-д он хүртэл монгол судлаачдын бичсэн зарим нэг эрдэм шинжилгээний өгүүллүүдийг оруулж өгчээ.

82.3/1/-6

Ж-24

/НХШУН унш-3ш/

Т-14851-14852

Катуу Б. **Баяд ардын аман зохиол** /Хян. Х.Сампилдэндэв. –УБ.: Соёмбопринтинг, 2011. - 606х.

Толилуун буй энэхүү номноос Монголын баяд ястаны гарал үүсэл, овог элхэн, удам судар, хэл соёл, түүх, зан үйл, аж ахуй, баяд ардын тууль, үлгэр, домог хууч яриа, ерөөл магтаал, ардын болон хохир дуунуудтай танилцах болно.

82.3/1/-6

К-29

/НХШУН унш-3ш/

Т-14847-14848



Галбаатар Д. **Эрин цаг.** Зохист аялгуу. Зохиолч. Уншигч: 2-р дэвтэр. –УБ.: Чөлөөт монгол, 2011. -100х.

Монгол улсын гавъяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Д.Галбаатарын энэ номонд түүнтэй хийсэн ярилцлага, мөн түүний өөрийн бичсэн найз нөхдийн тухай хөрөг найруулал, Монголын утга зохиолын тухай судалгааны өгүүлэл, уран зохиолын шүүмжүүд оржээ.

83.3/1/

Г-19

/НХШУН унш-7ш/

Б-21020-21022

**XX зууны Нобелийн шагналтнууд:** Намтар, онч мэргэн үгс. 2 дахь хэвлэл. –УБ.: 2011. - 235х.


XX зууны утга зохиолын салбарт Нобелийн шагнал хүртсэн 96 зохиолчийн онч мэргэн үгс, тэдгээрийн уран бүтээлийн намтарыг уншигч олондоо засаж залруулан 2 дахь удаагаа толилуулж байна.

83.3

Х-50

/НХШУН унш-2ш/

Б-21044-21045

**УРАН ЗОХИОЛ**

Бавуудорж Ц. **Хүннү тууль:** Туульсын найраглал: Уйгаржин монгол ба кирилл бичгээр. – УБ.: Шинэ Азия групп, 2011. -228х. /CD-тэй/

Яруу найрагч Ц.Бавуудорж 1980-аад оны сүүлчээс уран бүтээлээ эхэлсэн. “Бүгээн анир”, ”Гумуда”, ”Салхин зүгээс цэцгийн цагаан цоморлиг шүхэрлэнэ”, ”Сарны шүлгүүд”, “Монголын их амар амгалан”, “Дорно зүгт өвс болно” зэрэг яруу найргийн номнууд хэвлүүлсэн ба зарим нэг бүтээлүүд нь англи, испани, япон, солонгос, мажар хэл дээр орчуулагджээ. Энэхүү туульсын найраглал ном нь “Монголын их амар амгалан”, “Дорно зүгт өвс болно”, “Бөхөн шарын нуруу” зэрэг яруу найргийн зохиолуудыг нь агуулсан 2 төрлийн CD-тэй ажээ.

84/1/2-5

Б-11

/НХШУН унш-3ш/

T-14915-14916

Бавуудорж Ц. **Дорно зүгт өвс болно:** Яруу найраг. Англи, Монгол хэл дээр. – УБ.: Тоонотпринт, 2011. – 288 х.




84/1/2-5

Б-11

/НХШУН унш-3ш/

Б-21067-21068



Мөнхбаатар Л. **Эрх чөлөөний бүжиг:** Яруу найргийн түүвэр / Ред. М. Уянсүх. – Дархан-Уул аймаг.: Мөнхийн үсэг, 2011. – 133 х.

84/1/2-5

М-81

Б-21009-21010

Цэнд Ц. **Харанхуйг атганам:** Яруу найраг /Ред. Б. Пүрэвсүрэн, Г. Аюурзана. – УБ.: Мөнхийн үсэг, 2011. – 227 х.

84/1/2-5

Ц-95

/НХШУН унш-3ш/

Б-21014-21016



Цоодол Д. **Хөөв:** Хүүрнэл зохиолууд /Хян. П. Пүрэвсүрэн. – УБ.: Сэлэнгэпресс, 2011. – 392 х.

Зохиолч Д. Цоодолын энэхүү ном нь үргэлжилсэн үгийн, тухайлбал өгүүллэг, тууж, эсээний цогцолсон ном болжээ.

84/1/2-44

Ц-78

/НХШУН унш-7ш/

Б-21001-21003

**Яруу эгшгийн чуулган** /Ред. Б. Норовсамбуу. – УБ.: Мөнхийн үсэг, 2011. – 545 х.

Энэ онд Дархан хот байгуулагдсаны хагас зуун жилийн ой тохиож байгаад Дархан хот Дархан –Уул аймагт ажиллаж амьдарч байсан, одоо ажиллаж амьдарч уран бүтээлээ туурвиж байгаа үе үеийн яруу найрагчид, шинэ заалуу уран бүтээлчдийн “Яруу эгшгийн чуулган” хэмээх энэхүү томоохон хэмжээний уран бүтээлийн эхмтгэл номоо анх удаа хэвлэн уншигчдынхаа оюуны мэлмийд толилуулан өргөн барьж байна.


84/1/2

Я-78

T-14876-14877



## ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖ



Чимид Б. **Хотын ногоон байгууламж, бага ландшафт дендрологийн үндэс.** –УБ.: Адмон, 2011. -368х.

Хотын экологийн нөхцлийг сайжруулах, цэвэр сайхан агаартай, утаагүй хот болох наад захын хэрэгцээ болсон хотын цэцэрлэгжүүлэлтэнд энэхүү гарын авлага ном нь зориулагджээ. Энэ ном нь ландшафтийн архитектур, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын экологийн нөхцлийг сайжруулах нь, хот цэцэрлэгжүүлэлтийн үндэс, Улаанбаатар хотын ногоон байгууламжийн мод, сөөг гэсэн 4 бүлэгтэй. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн мод, сөөг гэсэн бүлэгт мод сөөгний овогийн талаар дэлгэрэнгүй бичиж өнгөт зургийг хавсаргажээ.

85.118.7

Ч-62

/БШУН унш-7ш/

Б-21041-21043

## ГҮН УХААН, СЭТГЭЛ СУДЛАЛ

Бовуар С. **Дайвар хүйстэн:** Баримт ба домог. 1,2-р дэвтэр /Орч. М.Отгонбаяр, Л.Өнөржаргал, Б.Онон. –УБ.: Урлах эрдэм, 2010.

...Эмэгтэй хүн байна гэдэг юу гэсэн үг вэ? хэмээх асуулт надад төрдөг байсан ба үүнд би ядах юмгүй хариулчихна гэж бодлоо. Гэтэл уг асуудлыг анхааралтай авч үзэх төдийдөө л би энэ ертөнц эрчүүдэд зориулагдсаныг ойлгосон... хэмээн францын феминизм, жендерийн сонгодог зохиолч Симон дө Бовуар бичжээ. Түүний “Дайвар хүйстэн” хэмээх энэхүү зохиол бичигдсэнээсээ хойш бүхэл бүтэн жаран өнгөрсөн боловч эмэгтэй хүнийг, мөн түүнийг “бүтээгч” нөхцөл байдлыг үүн шиг тал бүрээс нь гүнзгий судлан үзсэн, өөртөө ч өрөөлд ч тал засалгүй, илэн далангүй, шудрага хандсан бүтээл өнөөг хүртэл хэвлэгдээгүй ба өрнийн эмэгтэйчүүд хэдэн үеэрээ ариун судар мэт уншиж судалж, хүмүүжиж иржээ.

87

/НХШУН унш-7ш/

1-р дэвтэр. -330х.

Б-21069-21071

Б-72

2-р дэвтэр. -576х.

Б-21072-21074



Тимс Р. **Ховс-алхам алхмаар:** Бүрэн хэмжээний гарын авлага /Орч. Ч. Алтангэрэл, Ред. А. Энхжаргал. – УБ.: Соёмбо принтинг, 2011. – 384 х.

Энэхүү номыг гайхалтай сэтгэлзүйч, ховсоор эмчлэгч, доктор Роберта Тимс бичсэн бөгөөд өөрийнхөө зорилгод хэрхэн ховс ашиглахыг өгүүлнэ. Зохиогч, “Ховс” гэж юу болох, хэрхэн үйлчилдэг тухай энгийн, ашигтайгаар тайлбарлажээ. Танд ахиц дэвшил, гэр бүлийн амьдрал, бусад олон асуудлыг шийдвэрлэх мэргэжлийн зөвлөгөөг санал болгож байна.

88.6

Т-41


/НХШУН унш-7ш/

Б-21004-21006

## НОМ ЗҮЙН БҮРТГЭЛ

Батцэцэг Ж, Энхжаргал Б. **Монгол улсад хөдөө аж ахуйн талаар хэвлэгдсэн ном бүтээлийн ном зүй:** Тэргүүн дэвтэр /Ред. Н. Эрдэнэцогт, Ж. Цэзэн. – УБ.: Мөнхийн үсэг, 2011. – 308 х.

Тус бүтээлд 1970-2009 оны хооронд Монгол орны хөдөө аж ахуйн салбарт хийгдсэн судалгаа шинжилгээний ажил, тус салбарын үйлдвэрлэл, тэдгээрийн ололт амжилтын ирээдүйн чиг хандлагын талаар бичигдсэн ном зохиолын тоймтой танилцах томоохон



хэмжэний лавлах бичгийг толилуулж байна. Энэхүү ном зүйн бүтээл нь иргэд, уншигчид, эрдэмтэн судлаачид, хөдөө аж ахуйн мэргэжлийн бүх шатны оюутан, суралцагсадын сонирхолыг зүй ёсоор татах бизээ.

91.9:4

Б-34

/НХШУН унш-2, Лав-1ш/

T-14899-14900



**Монгол улсын үндэсний номын сан дахь архивын бүртгэн мэдээлэх ном зүй: 1-5 дэвтэр. 1921-2010** /Ред. Д.Энхтунгалаг., Эмх. Б.Батэрдэнэ ба бус. –УБ.: Соёмбо принтинг, 2011. -466х.

Монгол улсын үндэсний номын сан өөрийн оронд хэвлэгдэн гарсан ном, хэвлэлийн бүтээгдэхүүн бүрээс нэг хувийг авч, архив фондонд эх материалаар нь хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээж буй билээ. Үндэсний номын сан 90 жилийн ойдоо зориулан 1921-2010 он хүртэлх тэрхүү бүтээлүүдийг бүртгэж, бүртгэн мэдээлэх номзүйн 5 боть номыг нийт уншигчиддаа толилуулж байна.

91

М-69

/НШУН унш-2, Лав -1ш/

1-р боть: 1921-1965. -466х.

T-14866-14867

2-р боть: 1966-1978. -532х.

T-14868-14869

3-р боть: 1979-1989. -626х.

T-14870-14871

4-р боть: 1990-2000. -412х.

T-14872-14873

5-р боть: 2001-2010. -580х.

T-14874-14875

### ОРОС ХЭЛДЭЭРХ НОМ

Гольман М.И. **Современная Монголия в оценках западных авторов.** –М.: 2010. -187с.

Современная Монголия, идущая по пути рыночных реформ и демократизация общественно-политической жизни, является объектом пристального внимания и изучения со стороны стран Запада. В книге раскрываются и анализируются позиции и оценки западных авторов относительно всех основных революционных преобразований, который произошли в Монголии после 1990 года в области политики, экономики, общественных отношений и идеологии.



72.4/1/

Г-60

/НХШУН унш-3ш/

C-84705-84706



Есенова Т.С. **Русская лингвокультура в Монголии.** –Элиста.: Изд-во Калм. Ун-та, 2010. -222с.

В монографии прослеживается история появления русского языка на территории Монголии, анализируется функционирование русской лингвокультуры в этой стране в разные периоды, рассматриваются язык и стиль русскоязычной публицистики Монголии, исследуется участие русского языка в лингвистическом оформлении местности, изучаются ключевые лингвокультуры единицы. Адресуется широкому кругу исследователей, разрабатывающих проблемы русского языка, лингвокультурологии и межкультурной коммуникации.

81.2/1/

Е-82

C-84707

Кручкин Ю. **Современная Монголия: Энциклопедический справочник.** –УБ.: 2011. -1154с.

Книга “Современная Монголия” содержит исчерпывающие сведения об истории современной Монголии, экономике, внешней и внутренней политике, демографии,



